



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2021 оны 04 сарын 14 өдөр

Дугаар 157

Улаанбаатар хот

┌ Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх ┐
тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох тухай


Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5, 14 дүгээр зүйлийн 14.1.5, Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.2.4, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.3, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаа эрхлэхэд тавигдах нөхцөл, шаардлага”-ыг батлах тухай 245 дугаар тогтоолын хавсралтын 9.6.6, 2020 оны 905 дугаар тогтоолын 2 дугаар заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Сүмбэр баялаг хорин зургаа” ХЗХ-ны хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосугай.

2. Тогтоол батлагдсантай холбогдуулан хоршооны хадгаламж, зээлийн үлдэгдэл, бусад төлбөр тооцоог барагдуулж, оноосон нэрийн ард “Хадгаламж, зээлийн хоршоо” гэсэн дэлгэрэнгүй эсхүл “ХЗХ” гэсэн товчилсон тэмдэглэгээг хасуулж, тусгай зөвшөөрлийн гэрчилгээг Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлэх, өөрчлөн байгуулах, татан буугдах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэж эргэн мэдэгдэхийг “Сүмбэр баялаг хорин зургаа” ХЗХ /Б.Хонгорзул/-нд үүрэг болгосугай.

3. “Сүмбэр баялаг хорин зургаа” ХЗХ-ны тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосонтой холбогдуулан тусгай зөвшөөрлийн гэрчилгээг хураан авч, Санхүүгийн зохицуулах хорооны бүртгэлд холбогдох өөрчлөлт хийж, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийт болон харьяалагдах татварын алба, Улсын бүртгэлийн ерөнхий газарт ажлын 10 хоногийн дотор мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН